

**БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛТНЫГ ДАВТАН СУРГАХ, МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ, МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ,  
СУНГАХ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, СУРГАЛТ ЭРХЛЭХ ЧИГ ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭХ ТӨРИЙН БУС МЭРГЭЖЛИЙН  
БАЙГУУЛЛАГЫН ТҮНШЛЭЛИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНТ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ  
БИЧИГТЭЙ ХОЛБООТОЙ ИРҮҮЛСЭН ТОДРУУЛГЫН ХАРИУ**

2023-12-13

Д/д	Асуулт	Хариулт
1.	<p>1. Сонгон шалгаруулалтын баримт бичгийг түншилсэн төрийн бус байгууллагууд тус тусдаа бэлдэж ирүүлэх үү? Аль эсвэл нийлээд дундаасаа нэг баримт бичиг байдлаар ирүүлэх үү?</p>	<p>Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах, сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх чиг үүргийг гүйцэтгэх төрийн бус, мэргэжлийн байгууллагын түншлэлийг сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтын баримт бичиг /Цаашид “Сонгон шалгаруулалтын баримт бичиг” гэх/-ийн 1.2.3-т “Түншлэл” гэж уралдаант шалгаруулалтад Иргэний хуулийн 476 дугаар зүйлд заасан Хамтран ажиллах гэрээ байгуулан оролцож байгаа төрийн бус байгууллагуудын нэгдлийг” гэж, 3.9.1-д “Барилгын салбарын сургалт эрхлэгч төрийн бус, мэргэжлийн байгууллагууд нь Иргэний хуулийн 476 дугаар зүйлийн 476.3-т заасан шаардлагыг хангасан хамтран ажиллах гэрээ байгуулан түншлэлээр оролцох бөгөөд холбогдох хүний нөөцийн мэдээллээ Маягт 2-д тусган, холбогдох нотлох баримтын хамтаар ирүүлнэ.” гэж тус тус заасан. Иймд Түншлэлийн удирдагч болон гишүүд нь барим бичгийн 3.6.1-д заасны дагуу 5.3.3 (а)-д заасан материалыг бүрдүүлж, тодотгосон Маягт 2.2-ийн хамт ирүүлнэ.</p>
	<p>2. Шалгаруулалтын баримт бичгийн 5.3.3-н (В) Хүний нөөцийн чадавхын саналд буй Сургалтын албаны хүний нөөцөд тавьж буй шалгуур үзүүлэлтэд зааснаар зохион байгуулагч болон сургалт эрхлэгч байгууллагуудын сургалтын албанд боловсролын доктор болон магистр зэрэгтэй, зөвлөх мэргэшсэн мэргэшлийн зэрэгтэй байхыг заасан байна. Энэ нь тийм оновчтой шаардлага биш гэж үзэж байна. Учир</p>	<p>Сонгон шалгаруулалтын баримт бичгийн 5.3.3.в-д заасан Сургалтын албаны хүний нөөцийн саналын шалгуур үзүүлэлтийг нягтлан үзсэний үндсэн дээр дараах байдлаар өөрчлөв.</p>

нь аливаа сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах, эрхлэн явуулахад тэр бүр салбарын мэдлэг мэргэжил шаардлагатай бус харин аливаа үйл ажиллагааг зохион байгуулах чадамж бүхий харилцааны болон бичиг хэрэг боловсруулах мэдлэг, чадвартай байх нь чухал юм. Иймд ихэнх сургалтын байгууллага менежмент, зохион байгуулах ур чадвар бүхий мэргэжилтэн авч ажиллуулдаг. Мөн ихэнх төрийн бус байгууллагуудын сургалтын чадамж, хамрагдах мэргэжилтний тоо хэмжээнээс хамаарч сургалтын алба нь 5-аас доошгүй мэргэжилтэн ажиллуулдаг. Тиймээс энэ шалгуур үзүүлэлтийг харгалзан үзэх.

Шалгуур үзүүлэлт			
Боловсрол зэрэг	Мэргэшлийн зэрэг	Оноо	Нийт оноо
Барилгын салбарын доктортой	- Зөвлөх зэрэгтэй архитектор -Зөвлөх зэрэгтэй инженер -Тэргүүлэх зэрэгтэй төсөвчин	16-20	20
Барилгын салбарын доктор	-мэргэшсэн зэрэгтэй бол		
Барилгын салбарын магистр	- Зөвлөх зэрэгтэй архитектор -Зөвлөх зэрэгтэй инженер -Тэргүүлэх зэрэгтэй төсөвчин		
Барилгын салбарын магистр-2 ба түүнээс дээш	-Мэргэшсэн зэрэгтэй бол	11-15	
Барилгын салбарын доктортой	-мэргэшсэн зэрэгтэй бол		
Барилгын салбарын магистр	- Зөвлөх зэрэгтэй архитектор -Зөвлөх зэрэгтэй инженер -Тэргүүлэх зэрэгтэй төсөвчин		
Барилгын салбарын магистр-2 ба түүнээс дээш	-Мэргэшсэн зэрэгтэй бол	6-10	
Барилгын салбарын магистр	- Зөвлөх зэрэгтэй архитектор -Зөвлөх зэрэгтэй инженер -Тэргүүлэх зэрэгтэй төсөвчин		
Барилгын салбарын магистр-2 ба түүнээс дээш	-Мэргэшсэн зэрэгтэй бол	0-5	
Барилгын салбарын магистр ба түүнээс дээш	-Мэргэшсэн зэрэгтэй бол		

Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах, сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх чиг үүргийг гүйцэтгэх төрийн бус, мэргэжлийн байгууллагын түншлэлийг сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтын Ажлын даалгавар /цаашид “Ажлын даалгавар гэх/-ын 5.1.1.а-д “сургалтын менежерийг оролцуулсан 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй, орон тооны сургалтын албатай байх” гэж заасан нь сургалтын албаны хүний нөөцийн орон тооны хамгийн бага үзүүлэлт юм. Иймд уг тодруулгад дурдсан саналыг шалгуур үзүүлэлтэд тусгах боломжгүй байна.

3. Мөн сургалт эрхлэгчийн хүний нөөцийн шалгуур үзүүлэлтэд хамрагдах хүний нөөц гэдэг нь сургалтад хичээл заадаг сургагч багш нарыг гэж ойлгож байна. Сонгон шалгаруулалт нь БХБС-ын 2017 оны 200 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажилтны давтан сургалт, сургалт мэргэжлийн зэрэг олгох дүрэм”-д заасан 3.5, 3.6-д заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлэх бөгөөд энэ нь боловсролын зэрэг олгох сургалт биш, салбарын мэргэжилтнүүдийг тухайлсан хүрээнд мэргэшүүлэх, чадавхжуулах сургалт тул сургагч багш нарын хувьд онол практик хосолсон агуулгын хүрээнд сургалт явуулдаг. Иймээс их сургалтын сургагч багш нар нь боловсролын өндөр зэрэгтэй бус, салбарын тухайлсан мэргэшлийн хүрээндээ мэргэжлийн мэдлэг, ур чадвар бүхий мэргэшлийн зэрэгтэй, салбарт дэвшилтэт техник, технологийг эзэмшсэн мэдлэг, ур чадвар бүхий салбарын хөгжлийг түүчээлэгч ИТА-ууд байдаг. Иймээс шалгуур үзүүлэлтийг харахад салбарын мэргэжилтнийг мэргэшүүлэх сургалт зохион байгуулагч гэхээс илүү аливаа мэргэжил олгох их дээд сургуулийн шалгуур үзүүлэлт тавьсан байна. Сургагч багш бүр боловсролын

Сонгон шалгаруулалтын баримт бичгийн Сургалт эрхлэгчийн хүний нөөцийн саналын шалгуур үзүүлэлтийг тогтоохдоо барилгын салбар мэргэжлийн үйл ажиллагаа тус бүрээс 6 ба түүнээс дээш тооны докторыг, тэдгээр докторууд нь бүгд зөвлөх болон тэргүүлэх зэрэгтэй бол 15 оноо, 6 ба түүнээс дээш тооны доктор, тэдгээрийн зарим нь зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй, зарим нь мэргэшсэн зэрэгтэй байвал 10 оноо, түүнээс бага бол 5 оноо өгнө гэсэн ойлголт юм. Сургалт эрхлэгчийн хүний нөөцийн шалгуур үзүүлэлтийг нягтлан үзэж дараах байдлаар өөрчлөв.

Сургалт эрхлэгчийн хүний нөөцийн саналын шалгуур үзүүлэлт:

<b>Шалгуур үзүүлэлт</b>			
Боловсрол зэрэг	Мэргэжлийн зэрэг	Оноо	Нийт оноо
Доктор-6 ба түүнээс дээш	- Зөвлөх зэрэгтэй архитектор - Зөвлөх зэрэгтэй инженер - Тэргүүлэх зэрэгтэй төсөвчин	15	15
Доктор-6 ба түүнээс дээш	- Зөвлөх зэрэгтэй архитектор - Зөвлөх зэрэгтэй инженер - Тэргүүлэх зэрэгтэй төсөвчин - Мэргэшсэн зэрэгтэй архитектор, инженер, төсөвчин	10	
Доктор-5 хүртэл	- Зөвлөх зэрэгтэй архитектор - Зөвлөх зэрэгтэй инженер - Тэргүүлэх зэрэгтэй төсөвчин - Мэргэшсэн зэрэгтэй архитектор, инженер, төсөвчин	0-5	
<b>Тайлбар:</b> Доктор нь барилгын салбарын мэргэжлийн үйл ажиллагааны хүрээ тус бүрээс 1 хүн байна. Хэвээр нэг хүрээнээс 2 ба түүнээс дээш докторын материалыг санал болгосон бол нэг хүний материалаар тооцно.			
Магистр-15 ба түүнээс дээш	- Зөвлөх зэрэгтэй архитектор - Зөвлөх зэрэгтэй инженер - Тэргүүлэх зэрэгтэй төсөвчин	15	15
Магистр-15 ба түүнээс дээш	- Зөвлөх зэрэгтэй архитектор - Зөвлөх зэрэгтэй инженер - Тэргүүлэх зэрэгтэй төсөвчин - Мэргэшсэн зэрэгтэй архитектор, инженер, төсөвчин	10	
Магистр-15 хүртэл	- Зөвлөх зэрэгтэй архитектор - Зөвлөх зэрэгтэй инженер - Тэргүүлэх зэрэгтэй төсөвчин - Мэргэшсэн зэрэгтэй архитектор, инженер, төсөвчин	0-5	
<b>Хүний нөөцийн чадавхын саналын нийт үнэлгээ</b>		<b>50 оноо</b>	

<p>докторын зэрэгтэй шаардлага тавивал манай салбарын мэргэжилтэнд олгодог 56 төрлийн мэргэшлийн хүрээний сургалтад хичээл заах мэргэжилтнүүд хүрэлцэхгүй. Иймд бодит байдлаас давсан энэ шалгуур үзүүлэлтийг дахин нягтлан харах.</p>	
<p>4. Шалгуур үзүүлэлт 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.23 хүрээснээс бусад мэргэжлийн зэрэг тус бүрээс 1 хүн байна. Хэрэв нэг хүрээснээс 2 ба түүнээс дээш докторын зэрэгтэй хүний материал санал болговол нэг хүний материалаар тооцно гэж заасан. Гэтэл доктор 6 ба түүнээс дээш, Доктор 5 хүртэл гэж 3 түвшнээр үнэлээд тус бүрийн оноог 15, 10, 0-5 гэж үнэлэх юм байна. Гэтэл нийт оноо нь эдгээртэй адил заасан байна. Доктор 7 зэрэгтэй, зөвлөх зэрэгтэй байвал <math>15 \times 7 = 105</math> оноо гэж тооцно гэсэн үг үү? Иймд энэ шалгуур үзүүлэлтийг үнэлэх хүний нөөцийн шалгуур үзүүлэлтүүдийн талаар дэлгэрэнгүй тайлбарлах.</p>	<p>Уг ойлгомжгүй нөхцөл байдлыг 2, 3 дахь асуултын дагуу сонгон шалгаруулалтын баримт бичгийн өөрчлөлтөөр залруулсан.</p>
<p>5. Маягт 2.1-д Сургалтын албаны хүний нөөцийн мэдээлэл гэдэгт нь оролцогч түншлэлд буй бүх байгууллагуудын сургалтын алба, нэгжид ажиллаж буй орон тооны үндсэн ажилтнуудаас гадна тухайн байгууллагын удирдлагын</p>	<p>Болохгүй. Заавал шаардана. Уг тодруулгатай холбогдуулан Маягт 2.1-ийг дараах байдлаар тодотгов.</p>

бүрэлдэхүүнд орсон, сургалтын үйл ажиллагааг зохицуулагч болон орон тооны бус мэргэжилтэн байж болох уу? Ийм тохиолдолд нотлох баримт бичиг болох Хөдөлмөрийн гэрээ, НД-ийн лавлагааг хавсаргахгүй байх боломжтой юу?

**Маягт 2.1.Сургалт зохион байгуулагчийн сургалтын албаны хүний нөөцийн мэдээлэл**

Тухайн байгууллагад эрхэлж буй албан тушаал	Ажилтны эцэг/эх, өөрийн нэр	Мэргэжил, Боловсролын зэрэг	Мэргэшлийн зэрэг	Ажилласан жил
Сургалтын менежер .....				
..... хариуцсан ажилтан.....				
..... хариуцсан ажилтан.....				

Дээр мэдээллийг дараах баримт бичгээр нотолсон байна. Үүнд:

- Ажилд томилсон тушаалын хуулбар;
- Хөдөлмөрийн гэрээ болон түүнтэй адилтгах бусад гэрээний хуулбар;
- Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, лавлагаа;
- Боловсролыг гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- Мэргэжлийн зэргийн гэрчилгээний хуулбар зэргээр нотолсон байна.

6. Маягт 2.2-г Түншлэл /сургалт эрхлэгч/-ийн гишүүний хүний нөөцийн мэдээлэл гэдэгт сургагч багш нарын мэдээлэл байх уу? сургалтын үйл ажиллагаатай холбогдох алба, нэгжийг хариуцсан мэргэжилтэн байх уу?

Тухайн алба, нэгжийг хариуцсан мэргэжилтэн нь сургагч багш бол Маягт 2.2-ийг дахин бөглөж, холбогдох материалыг хуулбарлан илүүлнэ. Энэхүү тодруулгатай холбогдуулан Маягт 2.2-ийг дараах байдлаар тодотгосон.

**Маягт 2.2. Түншлэлийн гишүүдийн сургагч багш нарын мэдээлэл:**

Д/д	Асуулт	Хариулт
<b>Ерөнхий мэдээлэл:</b>		
1.	Байгууллагын нэр:	
2.	Овог, нэр :	
3.	Мэргэжил:	
4.	Төрсөн он сар өдөр:	
5.	Регистрийн дугаар:	
5.	Мэргэжлийн холбооны гишүүнчлэл:	
6.	Хариуцсан ажил:	

**Боловсрол, мэргэшсэн байдлын талаарх мэдээлэл:**

Д/д	Сургуулийн нэр	Эзэмшсэн мэргэжил	Боловсролын зэрэг	Дипломын дугаар	Мэргэшлийн зэрэг	Элсэн орсон он	Төгсөн он
1.							
2.							

Д/д	Ажилласан байгууллага	Албан тушаал	Орсон он, сар, өдөр	Гарсан он, сар, өдөр
1.				
2.				

Дээрх мэдээллийг дараах баримт бичгээр нотолсон байна. Үүнд:

- Тушаалын хуулбар
- Ажиллаж байсан болохыг нотолсон баримт /Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар эсхүл Нийгмийн даатгалын лавлагаа, эсхүл ХХОАТ төлсөн баримт/;
- Боловсролыг гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- Мэргэжлийн зэргийн гэрчилгээний хуулбар зэргээр нотолсон байна.

**Тайлбар:** "Түншлэлийн гишүүд" гэдэгт сургалт зохион байгуулагч болон сургалт эрхлэгч төрийн бус, мэргэжлийн байгууллагууд бүгд хамаарна. Мөн сургалт эрхлэгчийн сургалтын албаны мэргэжилтэн нь сургагч багш бол холбогдох мэдээллийг энэ маягтад тусган, холбогдох материалыг хуулбарлан ирүүлнэ.

<p>7. Маягт 2.2-т “мэргэжсэн зэрэг” гэдэг мэдээллийг боловсролын мэдээлэл хэсэгт оруулсан байна. Гэтэл “мэргэжсэн зэрэг” гэдгийг ямар зэрэг гэж ойлгох вэ? Хэрэв боловсролын мэдээлэлд бөглөх хэсэг бол боловсролын /бакалавр, магистр, доктор гэм мэт/ зэрэг байх ёстой биш үү? Боловсролын зэрэг байж элссэн, төгссөн он гэж бичиж болох уу? Энэ маягтыг 2.1 шиг хялбар байлгаж болохгүй юу? Тухайн сургагч багшийн одоогийн эрхэлж буй ажил, албан тушаал, боловсрол, мэргэжлийн зэргийн байдал гэх мэт үндсэн мэдээллийг оруулаад, ажилласан байгууллагын түүх хэсгийг хасах боломжтой юу?</p>	<p>Маягт 2.2-т дурдсан алдааг залруулж “Боловсролын мэдээлэл” гэснийг “Боловсрол, мэргэжсэн байдлын мэдээлэл” гэж, “мэргэжсэн зэрэг” гэснийг “мэргэшлийн зэрэг” гэж өөрчилсөн. Харин ажилласан байгууллагын түүх хэсэг нь тухай албан тушаалтны туршлага, мөн мэргэшлийн зэргийн сургалтад хамрагдах шаардлагыг хангасан эсэхийг нягтлах зорилготой тул хасах боломжгүй.</p>
<p>8. Хэрэв Маягт 2.2-т сургагч багш нарын мэдээлэл байх бол яагаад заавал нийгмийн даатгалын лавлагаа байх шаардлагатай вэ? Зарим мэргэшлийн хүрээний сургалт жилд нэг удаа явагдана. Түүнд хичээл заадаг багш 8-аас дээш тооны мэргэжилтэн байна. Тэдгээрийн дотроос 1 цаг буюу 45 мин хичээл заах тохиолдолд Нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс илүү ХХОАТ-ын тухай хуульд зааснаар тухайн мэргэжилтэн өөрөө хялбаршуулсан горимоор татвараа төлж, тайлагнадаг,</p>	<p>Маягт 2.2-т мэдээллийг нотлох баримт баримтаар тухайн санал болгож буй мэргэжилтний ажлын туршлага, мэргэшсэн байдлыг нотлох зорилготой тул ажилд томилох тушаалаас бусад нотлох баримтыг ирүүлнэ. Харин “Хөдөлмөрийн гэрээ” гэснийг “Ажиллаж байсан болохыг нотолсон баримт /Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар эсхүл Нийгмийн даатгалын лавлагаа, эсхүл ХХОАТ төлсөн баримт/” гэж тодотгосон.</p>

<p>эсхүл гэрээт байгууллага нь тохиолдолд хэрхэн дүгнэх бэ?</p>	
<p>9. Шалгуур үзүүлэлтийн оноо хуваарилах нөхцөлийг харахад боловсролын зэрэг, мэргэшлийн зэрэг чухал бол Хөдөлмөрийн гэрээ байхад хангалттай гэж үзэх боломжгүй юу? Энэ талаар дэлгэрэнгүй тайлбарлах.</p>	<p>Тодотгосон Маягт 2.1, Маягт 2.2-ийн дагуу холбогдох материалыг ирүүлнэ.</p>
<p>10. Бүрдүүлэх баримт бичиг, маягт тус бүрийг харахад оролцогч болон түншлэлийн бүх байгууллагуудын энэ чиг үүргийг хэрэгжүүлэх чадамж, туршлага, ур чадвар, зохион байгуулалт, үйл ажиллагааны тогтвортой байдал зэргийг чухалчлан үзэхийг дурдсан байгаа ч яг шалгаруулж, үнэлэх, үнэлгээний оноо зэрэг нь шалгаруулалтын зорилгод үл тохирох үзүүлэлт байна. Иймд шалгуур үзүүлэлтийн үнэлэх үнэлгээ, онооны талаар дэлгэрэнгүй тайлбарлах.</p>	<p>Сонгон шалгаруулалтын баримт бичгийн 5.3.3-т зааснаар Ажлын хэсэг уралдаант шалгаруулалтад энэ баримт бичгийн хавсралтад заасан маягтын дагуу оролцогчийн ирүүлсэн санал, түүнийг нотолсон баримтыг үндэслэн дараах байдлаар үнэлнэ.</p> <p>А.Ерөнхий шаардлагын үзүүлэлт-5 оноо;</p> <p>Б.Материаллаг бааз, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн санал-45 оноо;</p> <p>В. Хүний нөөцийн чадавхын санал-50 оноо;</p> <p>Нийт-100 оноо болно.</p>

<p>11. БХБЯ-ны ТНБД-ын 2023-12-01-ний өдөр баталсан 2023/14 дугаар бүхий Ажлын даалгаврын гүйцэтгэх үүрэг болон шалгаруулалтын баримт бичигт ажлын цар хүрээг заахдаа “Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм”-ийн 3.5 буюу зохион байгуулагчийн 15 чиг үүргийн зөвхөн 3.5.6, 3.5.7, 3.5.10, 3.5.11, 3.5.13 гэсэн 5 чиг үүргийг хэрэгжүүлнэ гэсэн байна. Тэгвэл үлдсэн 10 чиг үүргийг ямар зорилгоор хассан, ямар байгууллага, ямар байгууллага, газар, нэгж гүйцэтгэх вэ? Дээрх хассан 10 чиг үүргийг зохион байгуулах байгууллага нь энэ сонгон шалгаруулалтад орохгүйгээр шууд сонгогдох байгууллага байх уу?</p>	<p>“Барилгын салбарын ажилтнуудыг мэргэшүүлэх, автан сургах ажлыг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгэх төрийн бус, мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулалтын ажлын даалгаврын 2. Гүйцэтгэх үүрэг хэсэгт “Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 200 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэжлийн зэрэг олгох дүрэм” /Цаашид “Дүрэм” гэх/-ийн 3.5.6, 3.5.7, 3.5.10, 3.5.11, 3.5.13-д заасан сургалт зохион байгуулагчийн чиг үүрэг болон дүрмийн 1 дүгээр хавсралтын 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.23-т зааснаас бусад барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах, сургалт зохион байгуулах, дүрмийн 3.6-д сургалт эрхлэгчийн чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.” гэж, сонгон шалгаруулалтын баримт бичгийн заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.” гэж заасан бөгөөд сургалт зохион байгуулагч нь уг дүрмийн 3.5-д заасан 15 чиг үүргээс дээр дурдсан 5 чиг үүргээс бусад чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана. Харин үлдсэн шалгалтын үйл ажиллагаатай холбоотой 5 чиг үүргийг сонгон шалгаруулалтгүйгээр барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагад шилжүүлэх асуудлыг судлан үзэж байна.</p>
<p>12. Ажлын даалгаврын 5.2.1-д заасан сургалт эрхлэгч чиг үүргийн хүрээнд мэргэшлийн хүрээ тус бүрд хичээл заадаг багш нарын мэдээлэл нь Түншлэлд буй бусад байгууллагуудынхаа багш нартай давхцаж болох уу? Хүрээ тус бүрд ордог бүх багш нарын мэдээлэл байх уу? Хүрээ тус бүрийн хичээл заадаг багш нараас төлөөлж 1 багшийн мэдээллийг оруулах уу?</p>	<p>Ажлын даалгаврын 5.2.1-д заасан сургалт эрхлэгч чиг үүргийн хүрээнд мэргэшлийн хүрээ тус бүрийн хичээл заадаг багш нарын мэдээллийг ирүүлэх бөгөөд сонгон шалгаруулалтын баримт бичгийн 3.9.2-т заасан шаардлага нь хичээл заадаг багш нарт мөн адил хамраах тул давхцаж болохгүй.</p>